



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/297

Улаанбаатар хот

Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн 3.4.2-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон зайн мэдээллийн технологийн мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Мэргэжлийн зөвлөлийн дарга, орлогч дарга, нарийн бичгийн даргыг сонгож газрын даргын тушаалаар батлуулахыг Орон зайн өгөгдөл, дэд бүтцийн газар (Ж.Гал)-т даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн "Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" А/71 дүгээр тушаал, 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн "Тушаалд өөрчлөлт оруулах тухай" А/118 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА



А.ЭНХМАНЛАЙ

1524011274

Газар зохион байгуулалт, геодези,
зураг зүйн ерөнхий газрын даргын
2024 оны 1/29 дугаар тушаалын
хавсралт

ОРОН ЗАЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ОРОН ТООНЫ БУС
МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Д/д	Овог, нэр	Байгууллага, албан тушаал	Мэргэжил, цол, зэрэг
1.	Ж.Гал	ГЗБГЗЗЕГ-ын Орон зайн өгөгдөл, дэд бүтцийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	Архитектор, Бакалавр
2.	П.Нямдаваа	ГЗБГЗЗЕГ-ын Мэдээлэл, технологийн хэлтсийн дарга	Газар зохион байгуулалт, кадастр, Магистр
3.	З.Нямбаяр	ҮСХ, Тооллого, Өгөгдлийн Шинжилгээний газар	Газар зохион байгуулагч, Магистр
4.	Э.Баярмаа	Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Хүний нөөцийн стратеги, менежментийн хэлтсийн зөвлөх	Геодезийн инженер, Магистр
5.	Г.Бямбахүү	МУИС, ШУС, Газар зүйн тэнхим, эрхлэгч	Газарзүйч, сансрын технологийн хэрэглээ, PhD
6.	Б.Жавзандулам	ШУТИС, Геологи, уул уурхайн сургуулийн ахлах багш	Геодезийн инженер, PhD
7.	Д.Дэжидмаа	“Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтэц” ТББ-ын тэргүүн	Уул уурхайн маркшейдер, Магистр
8.	Г.Өлзийсайхан	Монголын Геомэдээллийн холбооны ерөнхийлөгч	Кадастр, PhD
9.	Г.Хулан	ГЗБГЗЗЕГ-ын Орон зайн өгөгдөл, дэд бүтцийн газрын ахлах мэргэжилтэн	Геодезийн инженер, магистр